



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/183

Хэрлэн сум

Хайгуул устгалын
бүлэг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өмнөдэлгэр сумын Баянзүрх багийн нутагт илэрсэн байлдааны зориулалттай их бууны сум галт хэрэгслийг устгах ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штабаас томилогдсон Хайгуул устгалын бүлэгтэй хамтран зохион байгуулсугай.


2.Хайгуул устгалын бүлэг ажиллуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 926,160 (есөн зуун хорин зургаан мянга нэг зуун жаран) төгрөгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дугаар сарын 06-ны өдрийн
А/183 захирамжийн хавсралт

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ ЗҮЙЛСИЙН ХАЙГУУЛ,
УСТГАЛЫН БҮЛГИЙН ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт Үнэ (мян.төг)	Хянасан
1.	Түлш	литр	232	3130	726160	
2.	Хоолны зардал	хүн	10	20000	200000	
3.	Нийт				926160	